

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их  
сургуульд оюутан элсүүлэх журам  
батлах тухай

Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 7.3 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаал, АШУҮИС-ийн Дүрмийн 3.4.2 дахь хэсэг, АШУҮИС-ийн Захирлын зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд оюутан элсүүлэх журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Оюутан элсүүлэх ажлыг энэхүү журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Их сургуулийн элсэлтийн комисст үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Захирлын 2015 оны А/142 дугаар тушаалын I хавсралтын 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хяналт, шинжилгээ, үнэлгээний албаны дарга /Б.Амарсайхан/-д даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЦОЛМОН

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирлын 2019 оны .... дүгээр сарын ....-ны өдрийн ..... дугаар тушаалын хавсралт

## **АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

### **1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль (цаашид АШУҮИС гэнэ)-д 2019-2020 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхэд Монгол Улсын “Дээд боловсролын тухай хууль”, БСШУ-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам” болон энэхүү журмыг баримтална.

1.2. Оюутан элсүүлэх үйл ажиллагаа нь ил тод, шударга, хүртээмжтэй, тэгш байдлыг хангана.

1.3. Элсэлтийн журам, бүрэлдэхүүн сургуульд элсэх хөтөлбөр, элсэлтийн ерөнхий шалгалтын оноо тооцох болон холбогдох бусад мэдээллийг <http://burtgel.mnums.edu.mn/> цахим хуудсанд байршуулна.

### **2. ЭЛСЭЛТИЙН КОМИСС**

2.1. АШУҮИС-ийн Захирлын тушаалаар батлагдсан элсэлтийн комисс нь элсэлтийн үед баримтлах хэм хэмжээ, дэг журам, комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарилалт, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, явцын хяналт тавих, элсэгчдийн өргөдөл, гомдлыг тухай бүрт шийдвэрлэх зэрэг асуудлыг хариуцна.

2.2. Элсэлтийн комисс нь ажил үүргийн хуваарьтай холбоотой хариуцлагыг АШУҮИС-ийн холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд хүлээнэ.

2.3. Элсэлтийн комиссын дарга нь Боловсролын асуудал эрхэлсэн тэргүүн дэд захирал, нарийн бичгийн дарга нь Оюутны албаны дарга, гишүүд нь Санхүү эдийн засгийн газрын дарга, нягтлан бодогч, Мэдээлэл технологийн албаны

дарга, мэргэжилтнүүд, Оюутны албаны арга зүйч, мэргэжилтнүүд, бүрэлдэхүүн сургуулийн арга зүйч, мэргэжилтнүүд байна.

### 3. ЭЛСЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

3.1. АШУҮИС-д элсэхийг хүсэгчид нь бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой иргэн байна.

3.2. АШУҮИС-д элсэхийг хүсэгчид нь Боловсролын үнэлгээний төвийн хүчинтэй батламжтай, эсвэл 2019 онд Элсэлтийн ерөнхий шалгалт өгч батламж авсан, БСШУСЯ-наас баталсан босго оноог хангасан байна.

3.3. Улаанбаатар хотоос элсэгчид АШУҮИС-ийн Оюутан элсүүлэх журмын дагуу элсэнэ.

3.4. Аймаг, орон нутгаас элсэгчид МИДСК-ын элсэлтийн журмын дагуу элсэнэ.

3.5. АШУҮИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн тухайн жилийн төгсөгчдийг БСШУСЯ-наас баталсан их, дээд сургуульд элсэгчдийн босго оноог хангасан тохиолдолд хөтөлбөрүүдэд хуваарилан шууд элсүүлнэ.

3.6. Гадаад улсад ерөнхий боловсрол эзэмшсэн, улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын оноог Боловсролын үнэлгээний төвөөр дүйцүүлэн тооцуулж, дүйцүүлсэн батламж авсан элсэхийг хүсэгчдийг бүртгэнэ.

### 4. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДИЙГ БҮРТГЭХ

4.1. Бүртгүүлэхээс өмнө Боловсролын үнэлгээний төвийн Ерөнхий шалгалтын шалгуулагчийн буланд нэвтэрч өөрийн хувийн мэдээлэл болон дүнтэй танилцсан байна.

4.2. Элсэхийг хүсэгчид цахим хэлбэрээр элсэлтийн <http://burtgel.mnums.edu.mn/> хаягаар бүртгүүлнэ.

4.3. Элсэхийг хүсэгчид нь АШУҮИС-ийн элсэлтийн <http://burtgel.mnums.edu.mn/> бүртгэлийн вэб хаяганд Боловсролын үнэлгээний төвийн Элсэлтийн ерөнхий шалгалтын шалгуулагчийн буланд нэвтэрч байсан бүртгэлийн дугаар, нууц үгээр бүртгүүлнэ.

4.4. Элсэхийг хүсэгчид нь элсэлтийн бүртгэлийн хуудсанд хувийн мэдээллийг баталгаажуулна.

4.5. Элсэхийг хүсэгчид нь элсэхийг хүссэн хөтөлбөрүүдийг дугаарлан ялгаатайгаар сонгосон байна. Хамгийн бага дугаартай хөтөлбөр нь сонгохыг хүссэн хөтөлбөр байна.

4.6. Элсэхийг хүсэгчид нь бүртгүүлсэн бүлэг бүрийн бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлнө. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

## **5. ЭЛСЭГЧДИЙГ ШАЛГАРУУЛАХ БА ХӨТӨЛБӨР СОНГОХ**

5.1. Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог нэмэн нийт оноог гаргана. Бүртгэл хаагдсаны дараа бүлэг бүрээр, онооны дарааллаар шалгуулагчдыг жагсаана.

5.2. Аймаг, орон нутгаас элсэгчид нь тухайн аймагт МИДСК-аас томилогдсон Элсэлтийн комисст дурьдсан хугацаанд цахим үнэмлэх, ерөнхий шалгалтын батламжтай өөрийн биеэр хүрэлцэн ирж хуваарь сонголт хийнэ.

5.3. АШУҮИС-д элсэн суралцах хяналтын тоонд багтсан, болзол хангасан элсэгчдийн нэрс болон мэргэжлийн сонголтыг нээлттэй мэдээлнэ.

5.4. Элсэхийг хүсэгчдийн хэмжээст онооны нийлбэр тэнцсэн тохиолдолд проценталь хувь болон бүрэн дунд боловсролын гэрчилгээний дундаж дүнг харьцуулж шийдвэрлэнэ.

5.5. Элсэхийг хүсэгчдийн шалгаруулалтыг элсэлтийн ерөнхий шалгалтын дүн олон нийтэд зарласан өдрөөс эхлэн ажлын 10 хоногт багтаан явуулна.

## **6. АШУҮИС-Д СУРАЛЦАХ ЭРХ ОЛГОХ**

6.1. Хяналтын тоонд багтаж хөтөлбөр сонгосон элсэхийг хүсэгчдэд суралцах эрхийн бичгийг олгоно.

6.2. Элсэгчид нь суралцах эрхийн бичиг авахаар ирэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ болон түүнтэй адилтгах бичиг баримт (эх хувилбар)
- Хувийн хэрэг
- Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж (эх хувилбар)
- Иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах бичиг баримт (эх хувилбар)
- Сүүлийн 6 сард авахуулсан цээж зураг 4 хувь (3x4)
- Сургалтын төлбөрийг бүрэн төлсөн баримт

6.3. Хяналтын тоонд багтсан боловч заасан хугацаанд шаардагдах материалыг бүрдүүлж ирж, бүртгүүлээгүй тохиолдолд АШУҮИС-д элсэхээс татгалзсан гэж үзэн жагсаалтын дараах бүртгүүлэгчид элсэх эрхийг шилжүүлнэ.

6.4. Бүртгүүлсэн элсэгчид хүндэтгэх шалтгааны улмаас сурах боломжгүй болсон тохиолдолд тушаасан төлбөрийн 10 хувийг суутгаж олгоно.

## **7. ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭХ**

7.1. Бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

- Элсэлтийн комиссоос олгосон суралцах эрхийн бичиг
- Иргэний үнэмлэх
- Сургалтын төлбөрийг бүрэн төлсөн баримт

7.2. Сургалтын төлбөр бүрэн төлж бүртгүүлсэн элсэгчдийг АШУҮИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.

7.3. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэнтэй холбогдон гарах хариуцлагыг элсэгч өөрөө хүлээх ба энэ нь нотлогдсон тохиолдолд бүртгэлээс хасч дараагийн элсэгчийг бүртгэнэ.

7.4. Элсэгчдийг жил бүрийн 8 дугаар сарын 3 дахь 7 хоногт АШУҮИС-д бүртгэж, суралцах гэрээ байгуулан 8 дугаар сарын сүүлийн 7 хоногт Удиртгал хичээл эхэлнэ.

7.5. Дурьдсан хугацаанд бүртгүүлээгүй элсэгчийн суралцах эрхийг цуцална.

7.6. Шинээр элссэн оюутнууд нэгдсэн журмаар АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт орно.

## 8. БУСАД

8.1. БШУ-ны Сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалын 7.1 дэх хэсгийг үндэслэн АШУҮИС-д дараах тохиолдолд Элсэлтийн ерөнхий шалгалтгүй элсүүлэн суралцуулж болно.

8.1.1. Дээд боловсролтой иргэн, 3 ба түүнээс дээш голч дүнтэй хоёр дахь дээд боловсрол эзэмшихийг хүсэгчид;

8.1.2. Дипломын дээд боловсролтой иргэн, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан, мэргэжлийнхээ дагуу шаталсан бакалаврын хөтөлбөрт элсэхийг хүсэгчид;

8.2. Засгийн газар хоорондын гэрээ, АШУҮИС-ийн гадаад хамтын ажиллагааны гэрээгээр болон хувийн төлбөрөөр суралцах хүсэлтэй гадаадын иргэдийг АШУҮИС-ийн “Гадаадын иргэдийг суралцуулах журам”-ыг үндэслэн элсүүлнэ.

-----oOo-----

Бакалаврын түвшинд суралцахыг хүсэгчдийн элсэлтийн босго оноо тооцох хичээл, мэргэжил тус бүрээр

№	Индекс	Мэргэжлийн нэр	ЭЕШ-ын оноо тооцох хичээл	
			Хичээл1	Хичээл2
1.	091201	Хүний их эмч	Хими	Биологи
2.	091701	Уламжлалт анагаахын их эмч	Хими	Биологи
3.	091101	Шүдний их эмч	Хими	Биологи
4.	091401	Био-анагаах судлаач	Хими	Биологи
5.	091801	Нийгмийн эрүүл мэнд судлаач	Хими	Биологи
6.	091601	Эм зүйч	Хими	Биологи
7.	091702	Зүү төөнө засалч	Хими	Биологи
8.	061101	Эрүүл мэндийн мэдээлэл зүйч	Математик	Физик
9.	092301	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан	Биологи	Нийгмийн тухай мэдлэг
10.	091703	Уламжлалт анагаах ухааны засалч	Хими	Биологи
11.	091301	Сувилахуй	Хими	Биологи
12.	091302	Эх барихуй	Хими	Биологи
13.	091501	Хөдөлгөөн засалч	Хими	Биологи
14.	091502	Ахуй засалч	Хими	Биологи
15.	102201	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал	Хими	Физик
16.	072102	Шим тэжээл судлал	Хими	Биологи
17.	D031101	Эрүүл мэндийн эдийн засагч	Математик	Физик

Дипломын боловсролын түвшинд суралцахыг хүсэгчдийн элсэлтийн шалгалтын тооцох хичээл, мэргэжил тус бүрээр

№	Индекс	Хөтөлбөрийн нэр	ЭЕШ-ын тооцох хичээл	
1.	НО3211-15	Дүрс оношлогооны техникч	Хими	Биологи
2.	НО3211-16	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн угсралт, ашиглалтын техник электроникч	Математик	Физик
3.	НО3251-13	Шүдний техникч	Хими	Биологи
4.	НО3251-12	Нүүр амны эрүүл ахуйч	Хими	Биологи
5.	НО3213-13	Эм найруулагч	Хими	Биологи
6.	НО3221-16	Уламжлалт анагаахын сувилагч	Хими	Биологи
7.	НО3256-14	Сувилагч	Хими	Биологи
8.	НО3212-17	Лабораторийн техникч	Хими	Биологи